

Сэдэв
Олон улсын тээвэрлэлтийн үйлчилгээ

Улаанбаатар хот
2018

АГУУЛГА

Агуулга

1. Олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагаа	4
1. Тээврийн хэрэгслийн сонголт	6
2. Олон улсын тээвэрлэлтийн төрөл	7
Хүснэгт 1. Үндсэн тээвэрлэлтийн төрлүүдийн онцлог, харьцуулалт	10
Хавсралт	11
Эх сурвалжийн жагсаалт	13

1. Олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагаа

Бараа бүтээгдэхүүнийг ямар нэгэн тээврийн хэрэгсэл ашиглан нэг газраас нөгөөд зөөж шилжүүлэх үйлдлийг тээвэрлэлт гэж ойлгож болох ба тээвэрлэлт нь бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон хэрэглээг холбож өгдөг гүүр учраас зах зээлд маш чухал үүргийг гүйцэтгэдэг.

Түүнчлэн бараа бүтээгдэхүүнд шаардлагатай тээврийн хэрэгслийг сонгосноор харилцагчийнхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, зардлаа хэмнэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх зэрэг олон чухал ач холбогдолтой.

Бид бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийг онцлон авч үзэж байгаа учраас зорчигч тээвэрлэлтийн тухай энд яригдахгүй.

Экспортын эсвэл импортын бараа таваар, түүхий эдийг нэг орон дахь ачилтын цэг /боомт, буудал, үйлдвэрийн агуулах/-ээс нөгөө орон дахь буулгах цэг /боомт, буудал, үйлдвэрийн агуулах/-т хүргэж нийлүүлэх үйл ажиллагааг олон улсын ачаа тээвэрлэлт гэнэ.

Олон улсын тээвэрлэлт нь хоёр болон түүнээс дээш орны нутаг дэвсгэрийг дамнуулан хийгддэг.

Олон улсын ачаа тээвэрлэлт нь хоёр болон түүнээс дээш тооны улсын хил боомтыг дамжин явагддаг учраас өөр өөр эрх зүйн, улс төрийн, газар зүйн, технологийн, цаг хугацааны, байгалийн давагдашгүй хүчин зүйл зэрэг маш олон нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай тулгардаг. Жишээлбэл Монгол улсад мөрдөгддөг хууль, журам зөвхөн Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилдэг бол хил давснаас хойш тухайн улсын хууль журмыг дагаж мөрдөх хэрэгтэй болдог.

Тээвэрлэлтийн зорилго:

- Тодорхой тогтоосон хугацаанд хэрэглэгчдэд эд зүйлс болон бүтээгдэхүүн, түүхий эдийг хүргэх.
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт ба борлуулалтыг холбож бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зах зээлтэй холбож өгөх.
 - Захиалга аваад-бараа нийлүүлэх, хүргэх хүртэлх үйл явцыг нэг жишигт оруулж, үр бүтээмжтэй болгох

Олон улсын худалдаанд оролцогч талуудын хооронд барааг тээвэрлэх үйл ажиллагаа нь дараах үе шатуудаар дамжин хэрэгжинэ. Үүнд:

1. Үйлдвэрлэсэн газраас экспортлогчийн орны хилийн боомт хүртлэх тээвэрлэлт
2. Хэрэв экспортлогчийн болон импортлогчийн орнууд хоорондоо эх газраар хиллэдэггүй бол экспортлогчийн орны хилийн боомтоос импортлогчийн орны хилийн боомт хүртэлх дамжин өнгөрөх болон далайн тээвэрлэлт
3. Импортлогчийн орны хилийн боомтоос таваарыг хүлээн авах цэг хүртэлх тээвэрлэлт

Олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагааг ачааг тээвэрлэж буй тээврийн хэрэгслээс нь хамааруулж *далайн, агаарын, төмөр замын, авто замын, дамжуулах хоолойн, холимог тээвэр* гэж ангилдаг. Манай орны хувьд тээвэрлэлт нь *агаарын, төмөр замын, авто замын тээвэрлэлт* гэсэн 3 үндсэн төрлөөс бүрдэнэ.

Харин тээвэрлэх ачааны шинж чанараас нь хамааруулан:

- Хуурай ачааны тээвэрлэлт
- Задгай ачааны тээвэрлэлт /нүүрс, баяжмал г.м./
- Шууд савлаж ачсан ачааны тээвэрлэлт /үр тариа, цемент г.м./
- Ердийн ачааны тээвэрлэлт /ширхэгийн/
- Шингэн ачааны тээвэрлэлт /нефть, нефтийн бүтээгдэхүүн, ургамлын тос г.м./ гэж ангилна.

Олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь зөвхөн нэг улс орны үндэсний хууль тогтоомжоор зохицуулагддаггүй, олон улсын эрх зүйн болон техник технологийн шинжтэй зохицуулах норм нормативуудыг шаарддагаараа онцлог. Тээврийн салбарын олон улсын гэрээ хэлэлцээрүүд нь улс орнуудын хооронд бараа тээвэрлэх ижил нөхцөл, барааг тээвэрлэх үйл ажиллагааг зохицуулах нийтлэг хэм хэмжээг агуулдаг билээ. Тэдгээр гэрээ хэлцлүүдэд тээврийн бичиг баримтуудад тавигдах шаардлагууд, ачааг хүлээн авах, шилжүүлэн ачих ба буулгах журмууд, ачааг эзэмшигч болон тээвэрлэгчийн эрх үүрэг, тээвэрлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын хооронд гарсан маргааныг зохицуулах журам зэргийг тусгадаг.

Тээвэрлэлттэй холбоотой эрх зүйн болон технологийн шинжтэй норм нормативийг хамарсан гэрээ хэлэлцээрийг байгуулахад оролцогч улс орны ашиг сонирхол, тэдгээр орны эрх зүйн болон технологийн норм норматив, тээвэрлэлтийн нөхцөл байдал, технологийн онцлог шинжүүдийг нь зайлшгүй харгалзан үзэхэд хүрдэг байна.

Улс орнуудын хилийн боомтуудын харилцаа холбоо, хилийн боомтоор бараа ба тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хил гааль, эрүүл ахуй, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтыг тавих журам, олон улсын тээврийн талаарх гэрээ хэлэлцээрүүд нь ачаа илгээгч болон хүлээн авагчийн үйл ажиллагааг хөнгөвчилж, тэдний хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалж, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж, гаалийн тарифын харилцаа, өмчлөх эрхийг нь хэрэгжүүлэх нөхцөл боломжийг нь хангах, тээвэрлэлтийн үеийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэдэг.

Түүнчлэн тээвэрлэлтийн үйл ажиллагааны үе шатуудад тодорхой улс орны үндэсний хууль тогтоомж, ёс заншил нөлөөлдөг байна. Тухайлбал, барааг ачих үед илгээгчийн орны, барааг буулгах үед хүлээн авагчийн орны үндэсний хууль тогтоомжийг мөрддөг.

2. Тээврийн хэрэгслийн сонголт

Олон улсын худалдааны чухал хэсэг болохын хувьд олон улсын тээвэрлэлт, тээвэрлэлтийн оновчтой бүтэц, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах нь Монгол Улсын эдийн засагт чухал байр суурь эзэлж байгаа асуудлын нэг юм.

Монгол улс нь далайгаас алслагдсан, далайд гарцгүй 29 орны нэг бөгөөд БНХАУ-тай 4 673 км, ОХУ-тай 3 845 км газраар хиллэдэг хоёр их гүрний хооронд оршдог газар зүйн онцлогтой, уул уурхайн үйлдвэрлэл зонхилсон улсын хувьд олон улсын тээвэрлэлт, түүгээр дамжуулан хийх гадаад худалдаа нь эдийн засгийн хөгжилд голлох нөлөө үзүүлэхүйц байр суурьтай.

Түүнчлэн газарзүйн байрлалын энэ онцлог нь манай улсын хувьд тээвэрлэлтийн өртөг зардлыг өсгөдөг болохыг анхаарах нь зүй. Тиймээс үйлдвэрлэгчдийн тэр дундаа экспортлогчдын хувьд тээврийн хэрэгслийн төрлөө оновчтой сонгох нь тэдний үйлдвэрлэсэн барааны гадаад зах зээл дээр өрсөлдөх чадварт нь нөлөөлдөг болохыг онцгой анхаарах шаардлагатай.

Олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагааны хүрээ зөвхөн барааг тээвэрлэх төдийгөөр хязгаарлагдахгүй. Барааг илгээгчийн агуулхаас ойрхон орших тээврийн боомт хүртэл зөөвөрлөх, тээврийн хэрэгсэлд ачаалах, хилийн боомт дээр өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих, хүлээн авах боомтод буулгах, ачааг боомтод түр хадгалах, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх, дахин

бүрдүүлэх г.м. дагалдах олон үйлчилгээг өөртөө агуулж байдаг билээ. Тээврийн эдгээр дагалдах үйлчилгээтэй холбоотой зардлууд дээр тээвэрлэлтийн зардлыг нэмэхэд ачааг эзэмшигчийн зүгээс гарах зардлын хэмжээ тодорхойлогдоно.

Тохирсон тээврийн хэрэгслийг сонгох гэдэг нь тодорхой зорилгод буюу таны ачааг аюулгүй, цаг хугацаанд нь хүргэж өгөх чадвартай, нийт зардал нь хамгийн бага байх тээврийн хэрэгслийг сонгоно гэсэн үг юм.

Экспортлогч ямар ангиллын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаагаасаа хамаараад өөрийн барааны шинж чанар буюу жин, овор хэмжээ, хадгалалтын онцгой нөхцөл, сав баглаа, үнэ зэрэг онцлогыг харгалзан тээврийн хэрэгслээ сонгох шаардлагатай тулгардаг.

Олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зөвхөн нэг тээврийн хэрэгслийн төрлөөр тээвэрлэгдэн хүлээн авагчдаа очих боломжгүй байх тохиолдол гарч болох юм. Учир нь үйлдвэрлэгч болон хүлээн авагчийн хоорондын зай алслагдах тусам газарзүйн байршлын янз бүрийн нөхцөл, хүлээн авагчийн байрлал, тухайн улсад хөгжсөн тээврийн төрөл хэлбэрээс шалтгаалан төмөр замаар дамжин авто зам, далайн тээврээр хүргүүлэх, эсхүл бараа бүтээгдэхүүний онцлогоос хамааран агаарын тээврээр дамжин авто тээврээр хүргүүлэх гэх мэтээр тээвэрлэлтийн холимог хэлбэрийг ашиглах нь элбэг тохиолдол юм. Тиймээс эдгээр тээвэрлэлтийн тус бүрийн онцлогыг харгалзан тээврийн хэрэгслээ сонгох шаардлагатай.

3. Олон улсын тээвэрлэлтийн төрөл

Олон улсын тээвэрлэлт хийх гэж буй экспортлогчид хамгийн хямд зардлаар, тогтоосон хугацаанд, бараа бүтээгдэхүүнээ найдвартай хүргэж нийлүүлэх үндсэн зорилготойгоор тээврийн хэрэгслээ сонгодог.

Үйлдвэрлэгч бүрийн бараа бүтээгдэхүүн өөр өөрийн онцлог шинж чанарыг өөртөө агуулж тэр хэрээрээ тээвэрлэлтийн янз бүрийн горимыг шаардах тохиолдол байж болох юм. Тухайлбал хурдны морь үржүүлж худалдахаар бол ямар төрлийн тээврийн хэрэгслээр хэрхэн тээвэрлэх вэ гэдэг асуулт гарч ирнэ.

Хэдийгээр манай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид тээврийн энгийн горим, сав баглаа боодол хэрэглэнэ гэж тооцож болох ч тэд цаашид үйлдвэрлэлээ хөгжүүлж томоохон экспортлогч болсон тохиолдолд зах зээлийн хүрээ тэлж, дэлхийн хаана ч бараа бүтээгдэхүүнээ хүргэж нийлүүлэх хэрэгцээ гарч, бүхий л

төрлийн тээврийн хэрэгслийг ашиглахаар төлөвлөж, эдгээр тээврийн хэрэгслийн онцлогийг сайтар судлах зайлшгүй шаардлагатай.

Тээврийн төрлүүдийн давуу болон сул талыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

Агаарын тээвэрлэлт: Богино хугацаанд харьцангуй хол зайнд түргэн хүргэх шаардлагатай барааг хүргэж нийлүүлэхэд давуу талтай. Харин өртөг зардал өндөр, бага хэмжээний ачаа тээдэг, цаг агаарын нөхцөл шууд нөлөөлдөг зэрэг сул талтай.



Авто замын тээвэрлэлт:

Ердийн буюу тусгайлсан зам шаардалгүй хүлээх авагчийн байгаа газар барааг шууд хүлээлгэн өгөх, хэрэглэгчийн хүссэн янз бүрийн хэмжээ, хэлбэрээр барааг тээж хүргэх боломжтой нь энэ тээврийн хэрэгслийн гол давуу тал юм. Харин харьцангуй өндөр үнэтэй, нэг удаагийн явалтаар харьцангуй бага ачаа тээдэг нь сул тал болдог.

Далайн тээвэрлэлт: Дамжуулах хоолойн тээвэрлэлтийг эс тооцвол хамгийн хямд өртөг зардлаар, их хэмжээний барааг тээвэрлэдэг тээврийн хэрэгсэл юм. Түүнчлэн тусгайлсан зам бэлтгэх шаардлагагүй зэрэг давуу талуудтай. Харин тээвэрлэх явц удаан, бараа бүтээгдэхүүн тээвэрлэлтийн явцад эвдрэх, гэмтэх магадлалтай зэрэг сул талуудтай.



Төмөр замын тээвэрлэлт:

Хуурай газрын тээвэрлэлтийн дотор их хэмжээний барааг нэг дор тээвэрлэх чадвартай бөгөөд цаг агаарын нөлөөлөл бараг байхгүй нь энэ төрлийн тээвэрлэлтийн давуу тал болдог. Гэвч анх барьж байгуулахад их хэмжээний зардал гардаг, зөвхөн тусгайлан зориулсан замаар л тээвэрлэлтийг хийдэг зэрэг сул талтай.

Дамжуулах хоолойн тээвэрлэлт: Хамгийн хямд тээвэрлэлт гэж үздэг. Гэвч энэ хэлбэрээр зөвхөн тухайлан заагдсан барааг буюу нефть, шатдаг хий тээвэрлэнэ.



Тээврийн хэрэгсэл бүр өөрийн давуу болон сул талтай байгааг харлаа. Тиймээс экспортлогч бүр өөрийн бүтээгдэхүүнд нийцсэн тээврийн хэрэгслийг сонгосноор тэдний зах зээл тэлж, орлого ашиг нь нэмэгдэж байдаг байна. Хүснэгт 1-ээс үндсэн тээвэрлэлтийн төрлүүдийн онцлог, харьцуулалтын талаар үзнэ үү.

Хүснэгт 1. Үндсэн тээвэрлэлтийн төрлүүдийн онцлог, харьцуулалт

	Төмөр замын тээвэр	Авто замын тээвэр	Далайн тээвэр	Агаарын тээвэр
Барааны жин	Их	Бага-дунд	Их-дунд	Жижиг-хөнгөн
Тээвэрлэх зай	Хол	Дунд-ойрхон	Хол	Хол
Тээврийн зардал	Дунд зэргийн тээвэрлэлтэнд ашигтай	Ойр зайны тээвэрлэлтэнд ашигтай	Холын зайны тээвэр-лэлтэнд ашигтай	Аль алинд нь ашигтай
Цаг агаарын нөлөөлөл	Бараг байхгүй	Бага зэрэг	Шууд	Шууд
Аюулгүй байдал	Найдвартай	Бага зэрэг	Бага	Бага
Тогтмол тээвэрлэлт	Хангалтгүй	Ашигтай	Хэцүү	Хэцүү
Жингийн хязгаарлал	Байхгүй	Байна	Байхгүй	Байна
Бараа цуглуулах	Төвөгтэй	Амар	Төвөгтэй	Төвөгтэй
Тээвэрлэх хугацаа	Урт	Урт	Маш урт	Маш бага
Ачаа ачих болон сав баглааны зардал	Энгийн	Энгийн	Үнэтэй	Хямд

Хавсралт

Тээвэр зууч, ложистикийн компаниудын холбоо барих хаяг

Ашли Транс ХХК	99108055, 99095381	import@ashleytrans.mn chuka@ashleytrans.mn finance@ashleytrans.mn
Глобал Ложистикс ХХК	99180220	global_lgstc@yahoo.com oyunaa_gl@yahoo.com
Ландэкс ХХК	55154894	gerel@landex.mn gerel@landex.us info@landex.mn account@landex.mn
Материал импекс ХК	99130933	oyun@materialimpex.mn baatartseren@materialimpex.mn nyamdulam@materialimpex.mn bolortuya@materialimpex.mn odbayar@materialimpex.mn
Анджин Транс ХХК	70117127, 70117129	info@andjintrans.com chinbaaa21@hotmail.com chinbaaa21@yahoo.com
Монгол Экспресс ХХК	313910, 319304, 319305	monexpress@magicnet.mn
МИАТ ХК	99117880, 379973, 88117129	marketing@miat.com batbaatar@miat.com
Монгол транс ХХК	70188807, 70188810, 99036343	mtc@mongoltrans.mn
Эйр транс ХХК	99262201	chuka@airtrans.mn info@airtrans.mn nomingoo_b@yahoo.com gantulga@airtrans.mn ariunzul@airtrans.mn
Эрин Интернэшнл ХХК	70000289	info@erininternational.mn sampil@erininternational.mn farida.h@erininternational.mn purevbaatar.b@erininternational.mn ganbold.b@erininternational.mn otgontuya.o@erininternational.mn info@erin-town.mn
УБ Транс ХХК	9,115,444,299,143,000	info@ubtrans.mn ubt@ubtrans.mn batbayar@ubtrans.mn account@ubtrans.mn customs@ubtrans.mn freight@ubtrans.mn
УБТЗ-ын ОУТЗуучлалын Төв ТӨҮГ	242586, 244845	info@ifc.mn
Трансгейт ХХК	242433	transgate@mbox.mn info@transgate.mn sodgerel.b@transgate.mn bukhbilegt@transgate.mn davaanorov@transgate.mn

Юу Ти Эл - Юнитранс Ложистикс ХХК	316802	admin@utl.mn info@utl.mn unitranslog@gmail.com
Ийст Винд ХХК	70110924	info@eastwind.mn
Монложистикс Ворлдвайд ХХК	70115454	admin@mlw.mn telenged@mlw.mn
Си Жэй Шиппинг Компанийн Төлөөлөгчийн газар	21-252352, 21-252997	s.sugar_76@yahoo.com
Туушин ХХК	312092, 312082, 945015, 320591	info@tuushin.mn zorigt@tuushin.mn enhry@tuushin.mn otgoo_7@tuushin.mn all@tuushin.mn uuganbayar@tuushin.mn oyunchimeg@tuushin.mn sales@bestwesternmongolia.mn
Ди Эйч Эл Глобал форвардинг ХХК	99021409	khulan.odgerel@dhl.com handa.s@dhl.com
Эм Жэ Ложистикс ХХК	98460245	tuvshin@mg-logistics.com
Монретранс ХХК	7,011,633,470,136,330	monretrans@gmail.com
Буянт Ухаа Трейд ХХК	88002968	bayarmaas@yahoo.com muujig_28@yahoo.com tsende1077@yahoo.com
Норд Групп ХХК	99096819	buyanzaya09@gmail.com buyanzayas@yahoo.com 905942401@qq.com
Монгол Тээвэр Нэгдэл ХХК	99322333	chimeddagva@mtn.mn finance@mtn.mn munkhorgi@mfe.mn
Монспэд ХХК	88111772	info@monsped.net

Эх сурвалжийн жагсаалт

1. Батнасан.Н., (2003), “Гадаад худалдаа: Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт”, хуудас 191-243.
2. Монгол банк, Бодлогын саналын судалгаа: Гадаад худалдааны тээвэр, логистикийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, Улаанбаатар 2012 он.
3. <https://www.slideshare.net/grane09/10-19032061>
4. https://www.dhl.mn/mn/logistics/freight_transportation.html
5. <https://www.slideshare.net/khina/14-42436611>